

АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ГАЗРААС ХЭРЭГЖҮҮЛЭХ
ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТЭД
ХИЙСЭН ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА
/2022 оны жилийн эцсийн байдлаар/

2023.01.24

Улаанбаатар хот

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго

Монгол Улсын хууль, Улсын Их Хурлын тогтоол, Монгол Улсын Засгийн газрын тогтоол, Монгол Улсын Засгийн газрын хуралдааны тэмдэглэлийн Ашигт малтмал, газрын тосны газраас хэрэгжүүлсэн тогтоол, шийдвэр, зүйл заалтуудын биелэлтийн явцад хяналт-шинжилгээ хийж, удирдлагыг үнэн зөв мэдээллээр хангах, төлөвлөсөн зорилтыг бүрэн биелүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд оршино.

Хоёр. Хяналт- шинжилгээ, үнэлгээний арга зүй

Монгол Улсын хууль, Улсын Их Хурлын тогтоол, Монгол Улсын Засгийн газрын тогтоол, Монгол Улсын Засгийн газрын хуралдааны тэмдэглэлийн хэрэгжилтийн тайлан, холбогдох мэдээ, мэдээллийг 2022 оны жилийн эцсийн байдлаар гаргуулан хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг баримталж ажиллав.

Эрх зүйн актын зүйл заалтыг тухайн жилд хэрэгжүүлсэн ажлын үр дүнгээр, нэг удаагийн үйлчлэлтэй бол шийдвэр гарсан өдрөөс хойш хэрэгжүүлсэн үйл ажиллагааны өссөн дүнгээр тооцож гаргалаа.

Хууль тогтоомж, тогтоол шийдвэр нь 2022 оны жилийн эцсийн байдлаар нийт 51, үүнээс Монгол Улсын хуулийн 31, УИХ-ын байнгын хорооны 20 заалтын биелэлтийг тус тус гарган хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ.

Гурав. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн

Ашигт малтмал, газрын тосны газарт 2022 оны бүтэн жилийн байдлаар нийт 51 тогтоол, шийдвэрийн заалтын 38 /74.5 хувь/ нь бүрэн биелэсэн, 11 /21.6 хувь/ заалт хэрэгжих шатанд, 2 /3.9 хувь/ заалт хэрэгжилт хангалтгүй гэж дүгнэгдсэн бөгөөд биелэлтийн дүн дундажаар **88.8** хувьтай үнэлэгдэв.

Мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8.2.4, 8.2.10, 8.4.12, 8.4.28-д заасан “хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайлан”, “мэдээлэл хариуцагчаас зохион байгуулах олон нийтийн арга хэмжээний хөтөлбөр”, “мэдээлэл хариуцагч болон захиалагч байгууллагын хүсэлтээр холбогдох этгээдийг худалдан авах ажиллагааны мэргэжил, арга зүйн зөвлөгөө, зааварчилгаагаар хангасан тухай мэдээлэл”-үүдийг байнга, нээлттэй ил тод байлгана гэж заасан мэдээллүүдийг одоогоор оруулаагүй байгаа тул үнэлээ хийгээгүй болно.

Тогтоол, шийдвэр	Бүгд	Шийдвэрийн төрлөөр						
		МУ-ын хууль	УИХ-ын тогтоол	УИХ-ын байнгын хорооны тогтоол	Ерөнхийлөгчийн зарлиг	ЗГ-ын тогтоол	ЗГ-ын хуралдааны тэмдэглэл	ЗГ-ын албан даалгавар
Заалт	51	31	-	20	-	-	-	-
Үнэлгээ	Биелэсэн: 100%	38	23	-	15	-	-	-
	Хэрэгжих шатанд: 70%	11	7	-	4	-	-	-
	Хэрэгжилт хангалтгүй: 30%	2	1	-	1	-	-	-
	Хэрэгжээгүй: 0%	-	-	-	-	-	-	-
Үнэлгээ: %	88.8	90.9	-	85.5	-	-	-	-

Дөрөв. Дүгнэлт

Ашигт малтмал, газрын тосны газарт 2022 оны жилийн эцсийн байдлаар хэрэгжсэн хууль тогтоомж, дээд газрын тушаал, шийдвэрийн хэрэгжилтийн үнэлгээг дундажаар **88.8** хувиар үнэлэв. Үүнээс Монгол Улсын хуулийн биелэлт 90.9 хувь, УИХ-ын байнгын хорооны тогтоолын биелэлт 85.5 хувийн биелэлттэй байна.

Тав. Зөвлөмж

Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8.3.5-д заасан “хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ”-г байнга ил тод, нээлттэй байлгана гэсэн мэдээллийг байгууллагын вэб хуудсанд байршуулахдаа мэдээллийг тодорхой оруулахад анхаарах, мөн УИХ-ын байнгын хорооны Газрын тосны бүтээгдэхүүний компанийн нөөц тогтоох тухай 2022.10.19-ний өдрийн 378 дугаар тогтоолын хэрэгжилт хангалтгүй байх тул дээрх хууль, тогтоол шийдвэрүүдийг хэрэгжүүлэхэд анхаарч ажиллах.

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ХЭЛТЭС